


САЛХИЙГ ҮЛЭЭЭ



Мальгозия Бартосик, Флиппа Наттал Жонс, Зэйм Задей
(Malgosia Bartosik, Philippa Nuttall Jones and Zam Zadeh)




2019 он хүүхдүүд уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох арга хэмжээ авахыг томчуудаас шаардан хичээл хаялт зарласан өөрчлөлтийн жил болон дурсагдана.

Хоёр ээж (Польш салхины эрчим хүчийг дэмжигч, Англи сэтгүүлч) болон Ираны авъяаслаг залуу уран бүтээлч нарын хооронд өрнөсөн ярианаас урам авсан энэхүү комик номоор сэргээгдэх эрчим хүч (салхи гэх мэт) нь хэрхэн дэлхий ертөнцийг хүн бүхэнд зориулагдсан илүү цэвэр, илүү эрүүл болж өөрчлөгдөхөд тусалдаг тухай өгүүлдэг.



2019 онд дэлхий даяар хүүхдүүд хичээл хаялт зарлав. Тэд багш нартаа дургүйдээ бус, харин томчуудад уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох арга хэмжээ авах хэрэгтэй гэж хэлэхийг хүссэн юм. Тэд сургуулиасаа завсарлага аван байж Эх дэлхийг хамгаалах хууль тогтоомж гаргах, тэдэнд цэвэр ирээдүйг өгөхийг уриаллаа.



Гэхдээ цаг уурын өөрчлөлт гэж яг юу вэ? үүнийг зогсоох нь яагаад тийм чухал юм бэ?
Үүнд хариулахын тулд бид цаг хугацаа руу буцах хэрэгтэй...
200 жилийн өмнө ихэнх хүмүүс хөдөө амьдардаг байв.



Дараа нь Аж үйлдвэрийн
хувьсгал ирэв.

Үйлдвэрүүд цэцэглэн хөгжиж,
хүмүүс хотод ажиллахаар нүүж
иржээ.

Эдгээр үйлдвэрүүд болон хожим
нь байшин, машин, онгоцнуудыг
ажиллуулахын тулд асар их
хэмжээний эрчим хүч шаардагдав.

Талбай дээр гараараа ажиллахын оронд машин ашиглан бүтээгдэхүүн
үйлдвэрлэх нь ерөнхийдөө ...
Илүү олон ажил.



Хүмүүс илүү их мөнгө олж, илүү их хоол хүнс худалдан авч, илүү урт
насалж, эрүүл саруул амьдарна.



Мөн аялалыг онгоц, машинууд хялбар
болгоно.




Гэхдээ үүний ихэнхи нь газрын тос, нүүрс, хий гэх мэт чулуужсан түлш шатааснаар боломжтой болдог. Чулуужсан түлш нь хэдэн зуун сая жилийн турш газар доор дарагдсан чулуужсан үхсэн амьтан, ургамлаас гаралтай.

Чулуужсан түлш нь шатахдаа нүүрстөрөгчийн давхар исэл* зэрэг хүлэмжийн хийг ялгаруулдаг.

Өөр нэг хүлэмжийн хий бол мал ихтэй томоохон фермээс ялгардаг метан* юм. Ялангуяа үхэр хивэх, унгах үед их ялгардаг.


*нүүрстөрөгчийн давхар исэл CO_2

* метан CH_4



Эдгээр хийнүүд нь нийлээд Дэлхийг бүрхсэн үл үзэгдэх нөмөргийг бий болгодог байна. Тэр нөмрөг нь харин нарнаас ирж буй хэт халуун туяаг Дэлхийд хадгалаад байдаг юм. Яг л хүлэмж шиг болгочихдог гэсэн үг.

Энэ нь Дэлхийг амьдрахад улам сайхан болгох ёстой л доо, гэхдээ хэрвээ энэ хийн нөмрөг нь хэтэрхий зузаан болчихвол, хэт халалт, уур амьсгалын өөрчлөлтийг авчирдаг байна.



Бид анх үйлдвэрлэл хөгжүүлж эхлэхэд Дэлхий маань 1 градус Цельсиэр дулаарчихсан юм. Нэгхэн градус гэхээр их сонсогдохгүй байж магад гэтэл чиний биеийн температур жаахан өсөхөд чи халуурдаг шиг Дэлхий ч бас тэгж өвдөж эхлэж байгаа юм.

Үер, хэт халуун болох зэрэг цаг уурын огцом өөрчлөлтүүд нь элбэг болж эхэлж байна.



Орчин тойрон нь огцом өөрчлөгдснөөс болж амьтан, ургамлууд амьдарч, ургахад улам хэцүү болж ховордож, устаж үгүй болж байна.



Хүмүүс ч бас үйлдвэрлэл, машинууд, хатуу түлшний хэт хэрэглээнээс болж гарсан агаарын бохирдлоос болж өвдөж, бүр зарим нь үхэж байна.



Бид бүгд үүнийг бууруулах эерэг хувь нэмэрээ оруулах ёстой.



Хэрэглээгүй үедээ гэрлээ тогтмол унтрааж байх нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулдаг.



Машинаар эсвэл онгоцоор явснаас автобусаар эсвэл вагоноор явах, алхах, дугуйгаар явах нь илүү бага бохирдол үүсгэнэ.



Мах бага идэх нь бас метан хийн ялгарлыг бууруулдаг.



Гэхдээ энэ хангалттай биш л дээ. Хатуу
түлшийг шатааж эрчим хүч гаргаж авах
нь хүлэмжийн хийн ялгарлын хамгийн
том шалтгаан юм.

Эдгээр хатуу түлшийг хэрэглэж
байснаас байгальд ээлтэй нар,
салхинаас гаргаж авсан эрчим хүчийг
яаралтай хэрэглэх шаардлагатай
байна.



Хүмүүс салхины эрчим хүчийг эрт дээр үеэс ашигласаар ирсэн.
Хамгийн анх далай тэнгисээр аялахдаа ашиглаж байв.




2000 жилийн өмнө анхны
салхин тээрмийг ус татах, гурил
нунтаглах гэж бүтээжээ.



Харин 19-р зууны сүүлчээр хэсэг эрдэмтэд
болон Дани улсын цаг уур судлаач Пул ла Кур
нар цахилгаан үйлдвэрлэхээр анхны салхин
турбиныг бүтээв.

1918 он гэхэд Дани улсад хэдийн 120 гаруй салхин турбин цахилгаан
үйлдвэрлэж байв. Гэвч бидний өнөөдрийн хэрэглэж байгаа гурван
далбаат салхин турбиныг 1978 онд Дани улсын инженерүүд анх удаа
гаргаж ирсэн.



Тэгвэл, салхин турбин яаж ажилладаг юм бол?

1-рт: Салхины хүч турбины далбааг эргүүлнэ.

2-рт: Эргэлтийн хүч хөдөлгүүрийг ажиллуулна.

3-рт: Хөдөлгүүр цахилгаан эрчим хүчийг үүсгэнэ.

4-рт: Ингээд ямар нэгэн хүлэмжийн хий ялгаруулахгүйгээр байшин, сургууль үйлдвэрүүдийг цахилгаанаар хангана.

5-рт: Мөн инженер, барилгачин, архитектор, эрдэмтэн зэрэг олон хүмүүст шинэ ажлын байр бий болгоно.



Анхны салхин турбинууд
19-р зууны үеийнхээс томгүй
байсан.

Харин одоогийн салхин турбинууд илүү
өндөр, сайн, удаан, хүчтэй болсон
бөгөөд эх газарт эсвэл далай тэнгист
харах боломжтой.

Дэлхийн хамгийн хүчирхэг турбины
зөвхөн нэг удаагийн эргэлтээс үүссэн
эрчим хүчээр танай байшинг бүтэн
өдрийн турш цахилгаан эрчим хүчээр
хангах боломжтой.

2025 он гэхэд, олон салхин
турбинууд Парисын
Эйфелийн цамхагаас ч
өндөр болно (нэг бүр нь
100 заанаас илүү хүнд).



Европ тивийг цахилгаанаар хангахад 130,000 гаруй салхин турбин хэдийн хувь нэмрээ оруулсаар байна. Өөрсдийн зан үйлийг эрчим хүчээ хэмнэдэг, орчноо бага бохирдуулдаг болгон өөрчилж салхины эрчим хүчийг нарны дэлгэц, цахилгаан машины хамт хэрэглэсэнээр бид цэвэр, эрүүл ирээдүйг бий болгож байна.



ИВЭЭН ТЭТГЭГЧ:

Wind[•]
EUROPE

windeurope.org



www.letthewindblow.org



Women in Wind Global Leadership Program-г
төлөөлөн Л.Баярмаа, Д.Пунсалмаа, Г.Үемаа
(Монголын салхины эрчим хүчний ассоциаци
/ Mongolian Wind Energy Association) нар
орчуулав.